



СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А/В

Улаанбаатар хот

Албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.3.2 дахь заалт, Соёл, Спорт, Аялал жуулчлал, Залуучуудын сайдын 2026 оны “Соёлын өвийн үндэсний төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай” А/2 дугаар тушаалын 2 дахь заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Батлагдсан зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарт багтаан тогтоосон Үндэсний төвийн орон тоо, албан тушаалын дагуу шинэчлэн боловсруулсан албан тушаалын тодорхойлолтыг хавсралт ёсоор баталсугай.

2. Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллахыг нийт ажилтан, албан хаагчдад, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Анхсанаа)-д даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Соёлын өвийн үндэсний төвийн захирлын 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн А/27 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ



Г.ЭНХБАТ

1720010084

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2026 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн
А/Б дугаар тушаалын хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
 Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Соёл, спорт, аялал жуулчлал,
залуучуудын сайдын 2026 оны А/2 дугаар
тушаал

Дагаж мөрдөх огноо:

2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Соёлын өвийн үндэсний төв

Нэгжийн нэр:

Захиргаа, удирдлагын газар

Албан тушаалын нэр:

Захиргаа, удирдлагын газрын дарга

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТҮ-11

Ажлын цаг:

08.30-17.30

Ажлын байрны албан ёсны байршил:

Хан-Уул дүүрэг, 21 дүгээр хороо, Буянт-Ухаа
2 хороолол

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Байгууллагын захиргаа, санхүү, хүний нөөц, хууль эрх зүй, бичиг хэрэг, гадаад харилцаа, төлөвлөлт, тайлагналт, дотоод хяналт болон гадаад харилцааны үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, байгууллагын үйл ажиллагааны үр ашиг, уялдаа холбоог хангах ажиллах чиг үүргийн хүрээнд гүйцэтгэлийн үр дүнг Үндэсний төвийн захирлын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хөдөлмөрийн дотоод журам бусад хэм хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах;
- Хүний нөөцийн бодлогыг төлөвлөх, хэрэгжилтийг хангаж удирдан зохион байгуулах, байгууллагын мэдээллийн ил тод байдалд хяналт тавих;
- Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, тайлан, дүн мэдээний боловсруулалтад хяналт тавих, судалгаанд суурилсан хэтийн чиг төлөв байдлыг тодорхойлох, бүтцийн чиг үүргийн шинжилгээ хийх;
- Нэгжүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, дэмжлэг үзүүлэх, судалгаа, зөвлөгөөгөөр хангах;
- Харьяалах нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих, тайлагнах;
- Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр: Туслах -Т, Хариуцан гүйцэтгэх -Г Хянах -Х Шийдвэрлэх -Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Хөдөлмөрийн хууль болон бусад хууль тогтоомж, төрийн албаны стандартыг хангах, байгууллагын хэмжээнд мөрдөгдөж буй дүрэм, журмын хэрэгжилтийг хангах, шинэчлэх, хэрэгжилтэд хяналт тавих;	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.	Х
	2. Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, хяналт тавих;	Хөтөлбөрийн хэрэгжилт 90 хувиас дээш байна.	Г, Х
	3. Албан хаагчдыг идэвхтэй ажиллахад манлайлж ажиллах, үйл ажиллагаатай холбоотой асуудлыг шуурхай шийдвэрлэх, чиглэл өгөх;	Албан хаагчдын ажлын гүйцэтгэл сайжирсан байна.	Г, Х
	4. Үндэсний төвийн захирлын баталсан тушаалын хэрэгжилтийг хангуулах, биелэлтэд хяналт тавих, удирдлагаар хангах;	Тушаал хэрэгжсэн байна.	Х
2 дугаар зорилтын хүрээнд	1. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтийг хангах;	Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангаж ажилласан байна.	Х, Ш
	2. Байгууллагын санхүүгийн хэрэгцээ, шаардлагыг үнэн зөв тодорхойлон жил бүрийн төсвийн төслийг боловсруулан батлуулах;	Төсвийн тухай хуулт, холбогдох журам, аргачлалд нийцсэн байна.	Х
	3. Худалдан авах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, удирдан зохион байгуулах;	Холбогдох хуулийн дагуу зохион байгуулсан байна.	Х
	4. Байгууллагын албан ёсны www.ncch.gov.mn сайтад оруулах байгууллагын үйл ажиллагааны нээлттэй мэдээллийг бэлтгэх ажлыг удирдан зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;	Нийтийн мэдээллийн ил тод байдал хангагдсан байна.	Х
3 дугаар зорилтын хүрээнд	1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, тайлагналыг хугацаанд нь бодитой дүгнэх,	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг хугацаанд нь тайлагнасан байна.	Х
	2. Хууль журамд заасан хугацаанд тайлан, мэдээг боловсруулж, зохих газарт хүргүүлэх ажлыг зохион байгуулах;	Тайлан мэдээг хугацаанд нь зохих газарт хүргүүлсэн байна.	Г, Х

	3. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хангаж, барилга, байгууламжийн ашиглалт, үйлчилгээний байдалд хяналт тавих, шаардлагатай асуудлыг Захиргааны зөвлөлөөр шийдвэрлүүлэх;	Байгууллага хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдсэн байна.	Х, Ш
	4. Байгууллагын чиг үүргийн шинжилгээг тогтоосон хугацаанд аргачлалын дагуу зохион байгуулах;	Үйл ажиллагааны үр дүн дээшилсэн байна.	Г, Х
	5. Байгууллагын дэргэдэх зөвлөлүүдийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах, дэмжлэг үзүүлэх;	Зөвлөлүүдийн үйл ажиллагаа хангагдсан байна.	Х, Ш
	6. Байгууллагын санхүүгийн тайланг холбогдох хууль тогтоомжийн дагуу тайлагнах үйл ажиллагаанд хяналт тавих;	Санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанд тайлагнасан байна.	Х
4 дүгээр зорилтын хүрээнд	1. Бусад нэгжийн ажлын төлөвлөлт, хэрэгжилт, үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн зөвлөн туслах, арга зүйгээр хангах, дэмжлэг үзүүлэх;	Нэгжийн үйл ажиллагааны хэрэгжилт сайжирч, ажлын үр дүн дээшилсэн байна.	Х, Ш
	2. Хамтран газар, нэгжийн дотоод үйл ажиллагааны журам боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг хангах;	Журам хэрэгжсэн байна.	Х, Ш
	3. Хэрэгцээт тоног төхөөрөмжийн захиалгыг хянаж, ажлын байрны нөхцөлийг судалж, сайжруулах арга хэмжээг авах;	Хэрэгцээт тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.	Ш
5 дугаар зорилтын хүрээнд	1. Нэгжийн үйл ажиллагааг удирдаж, албан хаагчдад чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, ажлын гүйцэтгэлийг дүгнэх, хяналт тавих;	Албан хаагчдын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажилласан байна.	Х, Ш
	2. Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулах, хэрэгжилтийг хангах, хяналт тавих, тайлагнах;	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байна.	Х, Ш
	3. Албан хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх, сургалтад хамруулах, шагнаж урамшуулах, сахилга хариуцлагыг сайжруулах санал боловсруулж шийдвэрлүүлэх;	Удирдлагын шинэ арга нэвтэрч, байгууллагын соёл төлөвшсөн байна.	Х, Ш
	4. Эрхлэх асуудлын хүрээнд бусад нэгж, ажилтан болон гадны байгууллагатай харилцах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах ажлыг зохион байгуулах;	Ажлын уялдаа холбоог зохицуулан ажилласан байна.	Х, Ш
	5. Албан хэрэг хөтлөлтийн хууль, журам, стандартыг мөрдүүлэх, баримт бичгийн зохион бүрдүүлэлт, байгууллагын архивын үйл ажиллагаанд хяналт тавих;	Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль, журам,	Х

		стандарт хэрэгжсэн байна.	
6 дугаар зорилтын хүрээнд	1. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг баримтлан ажиллах;	Хууль тогтоомж хэрэгжсэн байна.	Г
	2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэхэд идэвхтэй хамтран ажиллах, хяналт тавих, дүрэм, журам боловсруулахад оролцох;	Хууль тогтоомж хэрэгжсэн байна.	Г
	3. Эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох баримтыг “Байгууллагын хөтлөх хэргийн жагсаалт”-ын дагуу архивд шилжүүлэх;	Хууль тогтоомж хэрэгжсэн байна.	Г
	4. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам болон бусад дүрэм, журмын хэм хэмжээг мөрдөх;	Хууль тогтоомж хэрэгжсэн байна.	Г
	5. Байгууллагын соёлыг төлөвшүүлэх, хамт олны үйл ажиллагаанд идэвхтэй оролцох.	Хамт олны үйл ажиллагаанд манлайлан оролцсон байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх;	
Мэргэжил	-Эрх зүй (042101), менежмент ба удирдахуй (041301-041307), соёл судлал (031401), түүх, археологи (0222).	
Мэргэшил	Төрийн үйлчилгээ болон захиргааны чиглэлээр мэргэшсэн бол давуу тал болно.	
Туршлага	Төрийн албанд 5-аас дээш, удирдах албан тушаалд 3 жил ажилласан байх;	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	- эрсдэлийг урьдчилан тооцоолох, гарах арга замыг тодорхойлох; - ажил үүргийг тэнцвэртэй хуваарилах; - албан хаагчидтай ижил тэгш харьцах; - бусад;
	Дүн шинжилгээ хийх	- мэдээлэлд тулгуурлан бүтэц, чиг үүргийн шинжилгээ хийх; - тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, үр дагаварын талаар бодлогын үндэслэлтэй зөвлөмж боловсруулах; - бусад;
	Асуудал шийдвэрлэх	- асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид оновчтой, шуурхай шийдвэрлэх; - гаргасан шийдвэрийнхээ талаар хариуцлага хүлээх; - аливаа харилцааг хэрэгжүүлэх арга зам болон байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний төсөлд санал өгөх; - бусад;
	Манлайлах	- ёс зүйгээр хамт олноо үлгэрлэн манлайлах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхуйц ажил хэрэгч харилцаа бий болгох;

		<ul style="list-style-type: none"> - бусдад хүндэтгэлтэй, соёлтой, адил тэгш харьцах; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтын хувьд хамт олныг манлайлах; - бусад;
	Бусад	<ul style="list-style-type: none"> - албан хэрэг хөтлөх, бодлогын баримт бичиг боловсруулах; - гаргасан шийдвэрийнхээ талаар хариуцлага хүлээх; - гадаад хэлний мэдлэгтэй байх; - компьютерын хэрэглээний программ болон мэдээллийн технологийн дэвшилтэт аргыг ашиглах; - багаар ажиллах, багийн амжилтыг дэмжиж, бусдад таниулах; - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх; - бусад;

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

- Соёлын өвийн үндэсний төвийн захирал

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

- Ерөнхий нягтлан бодогч - 1
- Тооцооны нягтлан бодогч – 1
- Зохион байгуулагч -1
- Нярав - 1
- Хүний нөөцийн ажилтан - 1
- Дотоод хяналт, шалгалт хариуцсан ажилтан - 1
- Захиргааны мэргэжилтэн - 1
- Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн - 1
- Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн - 1
- Бичиг хэргийн эрхлэгч - 1
- Цахилгаанчин - 1
- Слесарь - 2
- Үйлчлэгч - 2

Бусад харилцах субъект:

- Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,
- Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага,
- Аймаг, нийслэлийн соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар,
- Төрийн болон 21 аймаг, нийслэл, орон нутгийн музей,
- Соёлын өвийг өмчлөгч, эзэмшигч төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэд.

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Албан тушаал: ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

..... Г.АНХСАНАА

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн
нэр)

2026 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Байгууллагын нэр: Соёлын өвийн үндэсний
төв

Шийдвэрийн огноо: 2026.03.16

Дугаар: А/13

(Тамга/тэмдэг)

ЗАХИРАЛ Г.ЭНХБАТ

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр,
өөрийн нэр)

2026 оны 03 дугаар сарын 16 -ны өдөр

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн
А/13 дугаар тушаалын хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
 Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: Соёл, спорт, аялал жуулчлал,
залуучуудын сайдын 2026 оны А/2 дугаар
тушаал

Дагаж мөрдөх огноо: 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Соёлын өвийн үндэсний төв

Нэгжийн нэр:

Захиргаа, удирдлагын газар

Албан тушаалын нэр:

Ерөнхий нягтлан бодогч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТҮМ-7

Ажлын цаг:

08.30-17.30

Ажлын байрны албан ёсны байршил:

Хан-Уул дүүрэг, 21 дүгээр хороо, Буянт-Ухаа
2 хороолол

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Байгууллагын үйл ажиллагааны төсвийн бүрдүүлэлт, зарцуулалт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах, хянах, байгууллагын жилийн төсвийн төсөөлөл болон төсөвтэй холбоотой төлөвлөгөөг боловсруулж батлуулах, сар, улирал, жилийн тайлан, мэдээг хянах, удирдлагыг санхүүгийн шийдвэр гаргахад үнэн зөв мэдээллээр хангах чиг үүргийн хүрээнд гүйцэтгэлийн үр дүнг Захиргаа, удирдлагын газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- Санхүүгийн бүхий л бүртгэл хөтлөлтийг хянах, шалгах;
- Санхүүгийн тооллого, тооцоог хийж хянах, зохих бүртгэл хийх;
- Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааны тайлан хийх;
- Байгууллагын аж ахуйн төсөв хийх, гэрээ байгуулах, хөрөнгийн зарцуулалт, байгууллагуудтай тогтмол болон хувьсах зардлын тооцоо хийх, материаллаг нөөцийг хөгжүүлэх, зохицуулах, ашиглалтад хяналт тавих.
- Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр: Туслах -Т, Хариуцан гүйцэтгэх -Г Хянах -Х Шийдвэрлэх -Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Санхүүгийн бүх төрлийн анхан шатны бүртгэлд хяналт тавих, байгууллагуудтай байгуулсан гэрээнд хяналт тавьж, инкассын баримтуудыг шалгах;	Хууль, журмын дагуу санхүүгийн баримт бичиг бүрдсэн байна.	Г
	2. Автомашинд хийсэн урсгал болон их засвар, запас сэлбэгийг сольсон засварласан тухай тусгай бүртгэлд хяналт тавих;	Автомашинны засварын бүртгэлд хяналт тавьсан байна.	Х
2 дугаар зорилтын хүрээнд	1. Тооцооны нягтлан бодогч болон няравын үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэжлийн удирдлагаар хангах, зааварчлах;	Байгууллагын үйл ажиллагаа хэвийн, тасралтгүй явагдсан байна.	Г
	2. Хагас, бүтэн жилийн үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг зохион байгуулах, хянах;	Эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж ажилласан байна.	Г
	3. Нийтийн мэдээллийн ил тод байдал болон шилэн дансны тухай тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд санхүүгийн тайлан, мэдээллийг хянан баталгаажуулж, байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудаст байршуулахад хяналт тавих;	Мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилласан байна.	Г
	4. Ажилтнуудын сар бүрийн цалин хөлс, урамшуулал, ээлжийн амралт, илүү цагийн мөнгийг цаг тухайд нь тооцоолж олгох;	Холбогдох хууль, журмын дагуу олгосон байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1. Санхүүгийн тооцоолох цахим программыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэж жил, улирал, сар бүрийн татварын тайлан баланс, нийгмийн даатгалын тайлан, төсвийн тайлан, мэдээ, санхүүгийн болон хөрөнгийн тайлан хуульд заасан хугацаанд гаргах;	Хуульд заасан хугацаанд үнэн зөв тайлан гаргасан байна.	Г
	2. Жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор дараа оны төсвийн төслийг үндэслэлтэй боловсруулж дээд шатны байгууллагын санхүү, хөрөнгө оруулалтын газарт хүргүүлэх;	Төсвийн төслийг хугацаанд нь хүргүүлсэн байна.	Г
	3. Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн төсөл, төсвийн зарлага санхүүжилтийн гүйцэтгэлийн болон бүтээгдэхүүний тайланг тогтоосон хугацаанд холбогдох байгууллагад тайлагнах;	Санхүүгийн тайланг хугацаанд нь тайлагнасан байна.	Г

	4. Санхүүгийн холбогдолтой тайлан мэдээг хууль, журамд нийцүүлэн боловсруулж, баталгаажуулах, тайланд аудит хийлгэх;	Санхүүгийн тайлан үнэн зөв, бодитой гарч, санхүүгийн аудит хийгдсэн байна.	Г
	5. Санхүүгийн баримт, мэдээ, тайланд 2 дугаар гарын үсэг зурах;	Санхүүгийн үйл ажиллагаа хууль, журмын дагуу явагдаж зөрчил дутагдал гараагүй байна.	Г
	6. Жилийн эцсийн тайлан баланст дүн шинжилгээ хийх;	Тайлан хуулийн хугацаанд үнэн зөв гарсан байна.	Х
4 дүгээр зорилтын хүрээнд	1. Байгууллагыг эд аж ахуйн материалаар тасралтгүй хангах ажлыг зохион байгуулах;	Эд, аж ахуйн материалаар хангагдсан байна.	Г
	2. Байгууллагын материаллаг нөөцийг хөгжүүлэх, удирдах;	Материаллаг нөөцийн ашиглалтад шинжилгээ хийгдсэн байна.	Г
	3. Байрны урсгал засвар, өвлийн бэлтгэл, цахилгаан, бохир, дулааны асуудлын төсвийг төлөвлөх, хяналт тавих;	Байрны өвлийн бэлтгэл хангагдсан байна.	Г, Х
	4. Байгууллагын үйл ажиллагааны болон хэтийн төлөвлөгөө, төсөлд тусгагдсан мөнгөн, биет хөрөнгийн нөөцийг зүй зохистой зарцуулах;	Байгууллагын хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.	Г
	5. Байгууллагын дулааны болон эрчим хүчний төлбөр, нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгал татвар зэрэг бусад төлбөрийг цаг тухайд нь шилжүүлж холбогдох баримт материалыг бүрдүүлэх;	Байрны ашиглалтын төлбөрийг төлж, өр авлага үүсгээгүй байна.	Г
	6. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой төслийн төсвийн тооцоо, судалгааг хийх;	Судалгаа хийгдсэн байна.	Г
	7. Санхүү, аж ахуйн ажлыг төлөвлөх, удирдан зохион байгуулах, хянах, тайлагнах;	Санхүүгийн үйл ажиллагаа хэвийн доголдол үүсээгүй байна.	Г
5 дугаар зорилтын хүрээнд	1. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг баримтлан ажиллах;	Хууль тогтоомж хэрэгжсэн байна.	Г
	2. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам болон бусад дүрэм, журмын хэм хэмжээг мөрдөх;	Хууль тогтоомжийг мөрдөж ажилласан байна.	Г

3. Байгууллагын соёлыг төлөвшүүлэх, хамт олны үйл ажиллагаанд идэвхтэй оролцох.	Хамт олны үйл ажиллагаанд манлайлан оролцсон байна.	Г
4. Эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох баримтыг "Байгууллагын хөтлөх хэргийн жагсаалт"-ын дагуу архивд шилжүүлэх;	Хууль тогтоомж хэрэгжсэн байна.	Г
5. Иргэд, байгууллагаас ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдолд хугацаанд нь хариу өгөх;	Хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх;	
Мэргэжил	-Санхүү (0412), нягтлан бодох бүртгэл (0411),	
Мэргэшил	Санхүү, эдийн засаг, нягтлан бодох бүртгэлээр мэргэшсэн бол давуу тал болно.	
Туршлага	Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх;	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- гүйцэтгэж буй ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг цуглуулах, харьцуулах, дүгнэх, санал боловсруулах, үр дүнг тайлагнах, илтгэх ур чадвартай байх;
	Асуудал шийдвэрлэх	- тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах; - хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдлийг шуурхай гаргах, - хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх,
	Багаар ажиллах	- мэдлэг, туршлага, ур чадвараа бусадтай хуваалцах, хамтран ажиллах, - хамт олны эерэг, нээлттэй уур амьсгалыг бүрдүүлэх; - ёс зүйн хэм хэмжээг сахиж, ажил хэрэгч чанараараа бусдад үлгэрлэх, - ажлын цаг ашиглалт, хувийн зохион байгуулалт сайтай, - бусдад хүндэтгэлтэй, соёлтой, адил тэгш хандах, - бусад;
	Бусад	- албан хэрэг хөтлөх, бодлогын баримт бичиг боловсруулах, - албан ажлын чиг үүргийн дагуу зөвлөгөө, мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх, - бүтээлч, санаачлагатай ажиллах, - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах, - кирилл болон үндэсний бичгээр баримт бичиг боловсруулах чадвартай байх, - гадаад хэлний мэдлэгтэй байх;

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

- Захиргаа, удирдлагын газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

-Тооцооны нягтлан бодогч,
-Нярав.

Бусад харилцах субъект:

- Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,
- Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,
- Иргэн, хуулийн этгээд.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Албан тушаал: ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Байгууллагын нэр: СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Шийдвэрийн огноо: 2026.03.16

..... Г.АНХСАНАА

(Гарын үсэг)

(Эцэг/эх/-ийн нэр,
өөрийн нэр)

2026 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Дугаар: А/13

(тамга/тэмдэг)

ЗАХИРАЛ

Г.ЭНХБАТ

(Гарын үсэг)

(Эцэг/эх/-ийн нэр,
өөрийн нэр)

2026 оны 03 дугаар сарын 16 -ны өдөр

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн
А/13 дугаар тушаалын хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
 Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2026 оны А/2 дугаар тушаал

Дагаж мөрдөх огноо: 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Соёлын өвийн үндэсний төв

Нэгжийн нэр:

Захиргаа, удирдлагын газар

Албан тушаалын нэр:

Тооцооны нягтлан бодогч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТҮМ-6

Ажлын цаг:

08.30-17.30

Ажлын байрны албан ёсны байршил:

Хан-Уул дүүрэг, 21 дүгээр хороо, Буянт-Ухаа 2 хороолол

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зохих хууль журмын дагуу хөтлөх, байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг хэвийн жигд тасралтгүй явуулах, удирдлага болон Ерөнхий нягтлан бодогчийг үнэн зөв мэдээллээр хангах чиг үүргийн хүрээнд гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- Санхүүгийн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зохих хууль журмын дагуу хөтлөх;
- Байгууллагын болон нэгжийн дотоод үйл ажиллагаанд оролцох, тайлагнах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр: Туслах -Т, Хариуцан гүйцэтгэх -Г Хянах -Х Шийдвэрлэх -Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Санхүүгийн анхан шатны баримт бичгийг бүрдүүлэх, бүртгэл хөтлөх, журмын дагуу цэгцлэх;	Нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна	Г
	2. Няравыг өдөр тутмын арга зүйгээр хангаж, няравын тооцоо, материалын тайланг улирал бүр хянах;	Нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна	Г, Х
	3. Автомашин бүрд хийсэн урсгал болон их засвар, запас сэлбэг хаанаас хэрхэн сольсон засварласан тухай тусгай бүртгэл хөтлөх;	Нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна	Г
	4. Санхүүгийн программыг өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж сар, улирал, жилийн эцсийн тайлан бэлтгэх;	Холбогдох журамд нийцсэн байна.	Г
	5. Жолоочийн шатахууны тооцоо, бензин шатахууны зарцуулалтад хяналт тавих;	Нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна	Г,Х
	6. Сар, улирал бүр тогтмол гаргадаг татварын тайлан баланс, нийгмийн даатгалын тайлан, төсвийн тайлан бэлтгэж, хянуулах;	Холбогдох журамд нийцсэн байна.	Г
	7. Хагас, бүтэн жилээр үндсэн ба эргэлтийн хөрөнгийн тооллого хийж тооцоо бодох, оролцох;	Тайлан, тооллогод хийгдсэн байна.	Г
	8. Жил бүрийн 4 дугаар сарын 25-ны дотор хөрөнгө оруулалтын төсвийн саналыг үндэслэлтэй боловсруулж дээд шатны байгууллагын санхүү, хөрөнгө оруулалтын газарт хүргүүлэх;	Холбогдох хууль, журмын дагуу саналыг нэгтгэн гаргаж зохих газарт хүргүүлсэн байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1. Эрхэлсэн ажлын хүрээнд байгууллага болон нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийцүүлэн төлөвлөгөө боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг хангах, тайлагнах;	Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Г
	2. Дээд шатны байгууллага, албан тушаалтан, мэргэжлийн байгууллагаас өгсөн үүрэг, даалгавар, зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлэх, санал өгөх, үнэн зөв мэдээллээр хангах;	Үүрэг даалгавар, зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлсэн байна.	Г
	3. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг хэрэгжүүлж, цаг үеийн шаардлагаар гарсан ажлыг тухай бүр гүйцэтгэх, эрхэлсэн ажлын хүрээнд үнэн зөв мэдээллээр хангах;	Үүрэг даалгаварыг хэрэгжүүлсэн байна.	Г

	4. Байгууллагын удирдлагын шийдвэрийн дагуу ажлын хэсэг, зөвлөл, комиссын бүрэлдэхүүнд ажиллах;	Хүлээсэн үүргээ хугацаанд нь чанартай биелүүлсэн байна.	Г
	5. Санхүү, аж ахуйн холбогдолтой баримт бичгийг бүрдүүлж зохих журмын дагуу цэгцлэх, үдэх, архивт шилжүүлэх;	Архив, албан хэрэг хөтлөлтийн журамд нийцсэн байна.	Г
	6. Иргэд, байгууллагаас ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдолд хугацаанд нь хариу өгөх;	Хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх;	
Мэргэжил	-Нягтлан бодох бүртгэл (041101), эдийн засаг (0311),	
Мэргэшил	Санхүүгийн салбарын мэргэшлийн зэрэгтэй бол давуу тал болно.	
Туршлага	Мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан байх;	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- гүйцэтгэж буй ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг цуглуулах, харьцуулах, дүгнэх, санал боловсруулах, үр дүнг тайлагнах, илтгэх ур чадвартай байх; - бусад;
	Асуудал шийдвэрлэх	- тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах; - хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдлийг шуурхай гаргах, - бусад;
	Багаар ажиллах	- мэдлэг, туршлага, ур чадвараа бусадтай хуваалцах, хамтран ажиллах, - хамт олны эерэг, нээлттэй уур амьсгалыг бүрдүүлэх; - ёс зүйн хэм хэмжээг сахиж, ажил хэрэгч чанараараа бусдад үлгэрлэх, - нээлттэй, шударга байх, - бусад;
	Бусад	- санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр мэргэшсэн байх, - албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх, - хувийн зохион байгуулалт сайтай, цаг ашиглалт сайтай байх, - бүтээлч, санаачлагатай ажиллах, - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах, - кирилл болон үндэсний бичгээр баримт бичиг боловсруулах чадвартай байх, - гадаад хэлний мэдлэгтэй байх;

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

- Захиргаа, удирдлагын газрын дарга,
- Ерөнхий нягтлан бодогч.

<u>Албан тушаалд шууд харьяалан</u> <u>удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u>	<u>Бусад харилцах субъект:</u> - Байгууллагын ажилтан, албан хаагчид, - Иргэн, хуулийн этгээд,
V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:
Албан тушаал: ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.АНХСАНАА (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2026 оны ... дугаар сарын ... -ны өдөр	Байгууллагын нэр: Соёлын өвийн үндэсний төв Шийдвэрийн огноо: 2026.03.16 Дугаар: А/13 (тамга/тэмдэг) ЗАХИРАЛ Г.ЭНХБАТ (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2026 оны 03 дугаар сарын 16 -ны өдөр

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн
А/Б. дугаар тушаалын хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
 Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Соёл, спорт, аялал жуулчлал,
залуучуудын сайдын 2026 оны А/2 дугаар
тушаал

Дагаж мөрдөх огноо:

2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Соёлын өвийн үндэсний төв

Нэгжийн нэр:

Захиргаа, удирдлагын газар

Албан тушаалын нэр:

Нярав

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТҮ-4

Ажлын цаг:

08.30-17.30

Ажлын байрны албан ёсны байршил:

Хан-Уул дүүрэг, 21 дүгээр хороо, Буянт-Ухаа
2 хороолол

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Байгууллагын өмч хөрөнгө, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, хадгалалт хамгаалалтыг хариуцаж, түүний зарцуулалт, бүртгэлд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тайлагнах ажлыг хариуцан зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Бараа материал, хангамжтай холбоотой нягтлан бодох бүртгэлийн тайлан бэлтгэх, нягтлан бодогчид тайлагнах;
2. Байгууллагын үндсэн хөрөнгө, хангамжийн материал, эд зүйлсийн хадгалалт хамгаалалт, бүрэн бүтэн байдал, зарцуулалтад хяналт тавих, хуваарилах, олгох;
3. Байгууллагын болон нэгжийн дотоод үйл ажиллагаанд оролцох, тайлагнах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр: Туслах -Т, Хариуцан гүйцэтгэх -Г Хянах -Х Шийдвэрлэх -Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Эд хөрөнгийн орлого, зарлага, шилжилт хөдөлгөөний анхан шатны бүртгэл, тооцоог стандартын дагуу хөтлөх;	Нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна	Г
	2. Нягтланд анхан шатны баримтын бүрдүүлэлт, тайлан мэдээг хугацаанд нь гаргаж өгөх;	Нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна	Г
	3. Бараа материалын тоо хэмжээ, сав баглаа, боодлын бүрэн бүтэн байдал, чанарыг шалган хүлээн авах, олгох, хөрөнгийг бүртгэх ажлыг хэрэгжүүлэх;	Нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1. Албан хаагчдын ажлын хэрэгцээт хангамжийн материалаар хангах;	Хэрэгцээт материалаар хангасан байна.	Г
	2. Эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, албан хаагч бүрт ашиглалтын картыг бүртгэж хөтлөх;	Бүртгэл хөдөлгөөнийг хийсэн байна.	Г
	3. Хагас жил болон жилийн эцсийн тооллогод бэлтгэн тооллогод оролцон өр авлагагүй ажиллах;	Тайлан, тооллогод хийгдсэн байна.	Г
	4. Агуулах, бараа материалыг хадгалах журам, зааврыг баримтлах, эмх цэгцтэй байлгах;	Холбогдох журамд нийцсэн байна.	Г
3 дүгээр зорилтын хүрээнд	1. Эрхэлсэн ажлын хүрээнд байгууллага болон нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийцүүлэн төлөвлөгөө боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг хангах, тайлагнах;	Холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу дүгнэсэн байна.	Г
	2. Хариуцсан ажлын хүрээнд мөрдөж буй дүрэм, журмыг боловсронгуй болгох талаар саналаа боловсруулж, удирдлагад танилцуулж, шийдвэрлүүлэх;	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.	Г
	3. Дээд шатны байгууллага, албан тушаалтан, мэргэжлийн байгууллагаас өгсөн үүрэг, даалгавар, зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлэх, санал өгөх, үнэн зөв мэдээллээр хангах;	Үүрэг даалгавар, зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлсэн байна.	Г
	4. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг хэрэгжүүлж, цаг үеийн шаардлагаар гарсан ажлыг тухай бүр гүйцэтгэх, эрхэлсэн ажлын хүрээнд үнэн зөв мэдээллээр хангах;	Үүрэг даалгаварыг хэрэгжүүлсэн байна.	Г
	5. Байгууллагын удирдлагын шийдвэрийн дагуу ажлын хэсэг,	Хүлээсэн үүргээ хугацаанд нь	Г

	зөвлөл, комиссын бүрэлдэхүүнд ажиллах;	чанартай биелүүлсэн байна.	
	6. Байгууллагын санхүүгийн баримт бичгийг холбогдох журмын дагуу эмхлэн цэгцэлж байгууллагын архивд шилжүүлэх;	Архив, албан хэрэг хөтлөлтийн журамд нийцсэн байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх;		
Мэргэжил	-Нягтлан бодох бүртгэл (041101), эдийн засаг (0311), санхүү, банк, даатгал (0412)		
Мэргэшил	Нягтлан бодогч, няраваар ажилласан бол давуу тал болно.		
Туршлага	Мэргэжлээрээ 1-оос доошгүй жил ажилласан байх;		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- гүйцэтгэж буй ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг цуглуулах, харьцуулах, дүгнэх, санал боловсруулах, үр дүнг тайлагнах, илтгэх ур чадвартай байх; - бусад;	
	Асуудал шийдвэрлэх	- тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах; - хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдлийг шуурхай гаргах, - бусад;	
	Багаар ажиллах	- мэдлэг, туршлага, ур чадвараа бусадтай хуваалцах, хамтран ажиллах, - хамт олны эерэг, нээлттэй уур амьсгалыг бүрдүүлэх; - ёс зүйн хэм хэмжээг сахиж, ажил хэрэгч чанараараа бусдад үлгэрлэх, - нээлттэй, шударга байх, - бусад;	
	Бусад	- нягтлан бодох, няравын чиглэлээр мэргэшсэн байх, - албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх, - хувийн зохион байгуулалт сайтай, цаг ашиглалт сайтай байх, - бүтээлч, санаачлагатай ажиллах, - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах, - кирилл болон үндэсний бичгээр баримт бичиг боловсруулах чадвартай байх, - гадаад хэлний мэдлэгтэй байх;	

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

- Захиргаа, удирдлагын газрын дарга,
- Ерөнхий нягтлан бодогч.

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект:

- Байгууллагын ажилтан, албан хаагчид,
- Иргэн, хуулийн этгээд,

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Албан тушаал: ЗАХИРГАА,
УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Байгууллагын нэр: Соёлын өвийн үндэсний төв

Шийдвэрийн огноо: 2026.03.16

Дугаар: А/13

..... Г.АНХСАНАА

(Гарын үсэг)


(Эцэг/эх/-ийн нэр,
өөрийн нэр)

2026 оны ... дугаар сарын ... -ны өдөр

ЗАХИРАЛ Г.ЭНХБАТ

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр,
өөрийн нэр)

2026 оны 03 дугаар сарын 16-ны өдөр



Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн
А/13 дугаар тушаалын хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
 Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Соёл, спорт, аялал жуулчлал,
залуучуудын сайдын 2026 оны А/2 дугаар
тушаал

Дагаж мөрдөх огноо:

2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Соёлын өвийн үндэсний төв

Нэгжийн нэр:

Захиргаа, удирдлагын газар

Албан тушаалын нэр:

Хүний нөөцийн ажилтан

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТҮ-7

Ажлын цаг:

08.30-17.30

Ажлын байрны албан ёсны байршил:

Хан-Уул дүүрэг, 21 дүгээр хороо, Буянт-Ухаа
2 хороолол

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Байгууллагын хүний нөөцийн төлөвлөлтийг зохион байгуулалтын бүтэц, зорилгод нийцүүлэн хэрэгжүүлэх, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт, төрийн албаны стандарт, бусад холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулах, мэдээллийн сан бүрдүүлэх, тайлагнах чиг үүргийн хүрээнд гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- Байгууллагын хүний нөөцийн төлөвлөлтийг хийж, хүний нөөцийн холбогдох баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх, тайлагнах үйл ажиллагааг хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;
- Байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх, сургалтын төлөвлөгөө, хэрэгжилтэд хяналт тавих;
- Хүний нөөцийн бүртгэл, мэдээллийг бүрдүүлэх, хамгаалах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих;
- Байгууллагын болон нэгжийн дотоод үйл ажиллагаанд оролцох, тайлагнах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр: Туслах -Т, Хариуцан гүйцэтгэх -Г Хянах -Х Шийдвэрлэх -Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Байгууллагын хүний нөөцийн төлөвлөлтийг хэрэгжүүлэх, хөдөлмөрийн харилцаатай холбоотой журам, баримт бичгийг өөрчлөн шинэчлэх төслийг боловсруулж, удирдлагад танилцуулах, батлуулах, хэрэгжилтийг хангах, хяналт тавих;	Шинэчлэх төслийг боловсруулж, батлуулж, хэрэгжүүлсэн байна.	Г, Х
	2. Сул орон тоог олон нийтэд мэдээлэх, нөхөх, сонгон шалгаруулах ажлыг хариуцан зохион байгуулах;	Сул орон тоог мэдээлж, нөхсөн байна.	Г
	3. Хөдөлмөрийн харилцаатай холбоотой шийдвэрийн төслийг боловсруулж, батлуулах, мэдээлэх ажлыг зохион байгуулах;	Хууль, журамд нийцсэн байна.	Г
	4. Байгууллагын үйл ажиллагааны зорилт, бүтэц, зохион байгуулалт, ажлын байрны нэр, чиг үүргийн талаар судлан шийдвэрлүүлэх, бүтцийн өөрчлөлтийн санал боловсруулах;	Хүний нөөцийн холбогдох шийдвэр нь хуульд нийцсэн байна.	Г
	5. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэх, урамшуулах, ажлыг зохион байгуулах;	Ажлын гүйцэтгэл дүгнэгдсэн байна.	Г, Х
	6. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, албан хаагчдын цаг ашиглалтад хяналт тавих;	Хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х
2 дугаар зорилтын хүрээнд	1. Байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулах;	Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байна.	Г
	2. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;	Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1. Хүний нөөцийн бүртгэл, судалгаа гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх;	Мэдээллийн сан бүрдсэн байна.	Г
	2. Албан хаагчдын хувийн хэрэг, тоо бүртгэлийг хөтлөх, баяжуулах, хүний нөөцийн асуудалтай холбоотой судалгаа, мэдээ, тайлан гаргах;	Хуульд нийцсэн байна.	Г
	3. Хүний нөөцийн ил тод байдлыг хангах мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулах, шинэчилж байх;	Иргэд мэдээллээр хангагдсан байна.	Г
	4. Жендэрийн хууль тогтоомжоор байгууллагын хүлээсэн үүргийн хэрэгжилтийг зохион байгуулах;	Хууль хэрэгжсэн байна.	Г

	5. Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн нэгдсэн системд байгууллага, албан хаагчдын мэдээллийг тухай бүр оруулах, шинэчлэх;	Мэдээлэл үнэн зөв байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1. Эрхэлсэн ажлын хүрээнд байгууллага болон нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийцүүлэн төлөвлөгөө боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг хангах, тайлагнах;	Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Г
	2. Дээд шатны байгууллага болон удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах;	Үүрэг даалгаврыг хэрэгжүүлсэн байна.	Г
	3. Байгууллагын удирдлагын шийдвэрийн дагуу ажлын хэсэг, зөвлөл, комиссын бүрэлдэхүүнд ажиллах;	Хүлээсэн үүргээ хугацаанд нь чанартай биелүүлсэн байна.	Г
	4. Байгууллагын хүний нөөцийн баримт бичгийг холбогдох журмын дагуу эмхлэн цэгцэлж байгууллагын архивд шилжүүлэх;	Архив, албан хэрэг хөтлөлтийн журамд нийцсэн байна.	Г
	5. Иргэд, байгууллагаас ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдолд хугацаанд нь хариу өгөх	Хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх;	
Мэргэжил	-Эрх зүй (042), менежмент ба удирдахуй (041301-04), олон улсын харилцаа (031202), соёл судлал (031401), түүх, археологи (0222),	
Мэргэшил	Хүний нөөц, хууль эрх зүйн чиглэлээр ажилласан бол давуу тал болно.	
Туршлага	Төрийн албанд 2-оос доошгүй жил ажилласан байх;	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- гүйцэтгэж буй ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг цуглуулах, харьцуулах, дүгнэх, санал боловсруулах, үр дүнг тайлагнах, илтгэх ур чадвартай байх;
	Асуудал шийдвэрлэх	- тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах; - хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдлийг шуурхай гаргах, - хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх,
	Багаар ажиллах	- мэдлэг, туршлага, ур чадвараа бусадтай хуваалцах, хамтран ажиллах, - хамт олны эерэг, нээлттэй уур амьсгалыг бүрдүүлэх; - ёс зүйн хэм хэмжээг сахиж, ажил хэрэгч чанараараа бусдад үлгэрлэх, - хувийн зохион байгуулалт сайтай, ажлын цаг ашиглалтын хувьд хамт олныг манлайлах - бусдад хүндэтгэлтэй, соёлтой, адил тэгш хандах,

	Бусад	<ul style="list-style-type: none"> - хүний нөөцийн чиглэлээр мэргэшсэн байх, - албан хэрэг хөтлөх, бодлогын баримт бичиг боловсруулах, - албан ажлын чиг үүргийн дагуу зөвлөгөө, мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх, - бүтээлч, санаачлагатай ажиллах, - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах, - кирилл болон үндэсний бичгээр баримт бичиг боловсруулах чадвартай байх, - гадаад хэлний мэдлэгтэй байх.
--	-------	---



IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

- Захиргаа, удирдлагын газрын дарга

<u>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u>	<u>Бусад харилцах субъект:</u> <ul style="list-style-type: none"> - Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, - Төрийн албаны зөвлөл, - Иргэн, хуулийн этгээд.
---	--

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:
<p>Албан тушаал: ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ</p> <p> Г.АНХСАНАА (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)</p> <p>2026 оны ... дугаар сарын ... -ны өдөр</p>	<p><u>Байгууллагын нэр:</u> Соёлын өвийн үндэсний төв</p> <p><u>Шийдвэрийн огноо:</u> 2026.03.16</p> <p><u>Дугаар:</u> А/13 (тамга/тэмдэг)</p> <p>ЗАХИРАЛ  Г.ЭНХБАТ (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)</p> <p>2026 оны 03 дугаар сарын 16 -ны өдөр</p>

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн
А/13 дугаар тушаалын хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
 Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Соёл, спорт, аялал жуулчлал,
залуучуудын сайдын 2026 оны А/2 дугаар
тушаал

Дагаж мөрдөх огноо:

2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Соёлын өвийн үндэсний төв

Нэгжийн нэр:

Захиргаа, удирдлагын газар

Албан тушаалын нэр:

Захиргааны мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТҮ-7

Ажлын цаг:

08.30-17.30

Ажлын байрны албан ёсны байршил:

Хан-Уул дүүрэг, 21 дүгээр хороо, Буянт-Ухаа
2 хороолол

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналыг зохион байгуулах, дээд газрын тогтоол, шийдвэрийн биелэлт, байгууллагаас гаргаж буй захиргааны баримтуудыг боловсруулах, батлуулах, хүргүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүргийн хүрээнд гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг нэгтгэн боловсруулах, батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах, захиргааны баримтуудыг боловсруулах, батлуулах;
- Дээд газрын тогтоол, шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;
- Хамт олны болон Захиргааны зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах;
- Байгууллагын болон нэгжийн дотоод үйл ажиллагаанд оролцох, тайлагнах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр: Туслах -Т, Хариуцан гүйцэтгэх -Г Хянах -Х Шийдвэрлэх -Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгтгэн боловсруулах, батлуулах, батлагдсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, тайланг нэгтгэн тайлагнах, дээд газарт хүргүүлэх;	Төрийн бодлого, хууль тогтоомжид нийцсэн байна.	Г
	2. Байгууллагын үйл ажиллагааны хагас, бүтэн жилийн тайлангийн хурлын бэлтгэлийг хангаж, зохион байгуулах;	Мэдээллийн ил тод байдал хангагдсан байна.	Г
	3. Байгууллагын 7 хоног тутмын ажлын болон бусад холбогдох тайлан мэдээг нэгтгэж, удирдах дээд байгууллагад хүргүүлэх;	7 хоног тутмын ажлын тайлан мэдээг хүргүүлсэн байна.	Г
	4. Нэгжийн тухайн оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, батлагдсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэж тайлагнах;	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдсан байна.	Г
	5. Байгууллагаас иргэн, байгууллагатай байгуулж буй гэрээ, хамтын ажиллагааны баримт бичгийн төслийг боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулах;	Гэрээ, хамтын ажиллагааны баримт бичиг хууль, журмын дагуу батлагдсан байна.	Г
	6. Иргэн, байгууллагатай байгуулсан гэрээ, хамтын ажиллагааны баримт бичгийн дугаар олгох, бүртгэл хөтлөх, эх хувийг хадгалах, байгууллагын архивд шилжүүлэх;	Гэрээ, хамтын ажиллагааны баримт бичигт дугаар олгож, архивд шилжүүлсэн байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1. Дээд газраас ирсэн тогтоол, шийдвэр, үүрэг даалгавар, зөвлөмжийг бүртгэж, хяналтад авах;	Бүртгэл хөтөлж, хяналтад авсан байна.	Г, Х
	2. Тогтоол, шийдвэр, үүрэг даалгавар, зөвлөмжийн хэрэгжилтийг холбогдох нэгж, ажилтнаар гаргуулж, нэгтгэн удирдлагад танилцуулах, мэдээг холбогдох дээд газарт хүргүүлэх;	Тогтоол, шийдвэр, үүрэг даалгавар, зөвлөмж хэрэгжсэн байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1. Байгууллагын хамт олны хурлыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах, хэлэлцэх асуудал, хурлын зохион байгуулалтыг хангах, хурлын тэмдэглэлийг хөтлөх, албажуулах;	Хамт олны хурлыг зохион байгуулж, тэмдэглэлийг албажуулсан байна.	Г

	2. Захиргааны зөвлөлийн хурлыг журмын дагуу зохион байгуулах, тэмдэглэл хөтлөх, албажуулах, гарсан шийдвэрийг холбогдох нэгж, албан хаагчид танилцуулах, биелэлтийг нэгтгэн гаргаж, танилцуулах;	Захиргааны зөвлөлийн хурлаас гарсан шийдвэр хэрэгжсэн байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1. Эрхэлсэн ажлын хүрээнд байгууллага болон нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийцүүлэн төлөвлөгөө боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг хангах, тайлагнах;	Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Г
	2. Хариуцсан ажлын хүрээнд мөрдөж буй дүрэм, журмыг боловсронгуй болгох талаар саналаа боловсруулж, удирдлагад танилцуулж, шийдвэрлүүлэх;	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.	Г
	3. Дээд шатны байгууллага болон удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах;	Үүрэг даалгаврыг хэрэгжүүлсэн байна.	Г
	4. Байгууллагын удирдлагын шийдвэрийн дагуу ажлын хэсэг, зөвлөл, комиссын бүрэлдэхүүнд ажиллах;	Хүлээсэн үүргээ хугацаанд нь чанартай биелүүлсэн байна.	Г
	5. Эрхэлсэн ажлын талаар хийж гүйцэтгэсэн үйл ажиллагаатай холбогдох бичиг баримтуудыг эмхлэн цэгцэлж байгууллагын архивд шилжүүлэх;	Архив, албан хэрэг хөтлөлтийн журамд нийцсэн байна.	Г
	6. Иргэд, байгууллагаас ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдолд хугацаанд нь хариу өгөх;	Хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх;	
Мэргэжил	-Эрх зүй (042), менежмент ба удирдахуй (041301-04), соёл судлал (031401), түүх, археологи (0222), уран зохиол, хэл шинжлэл (0232)	
Мэргэшил	-	
Туршлага	Төрийн албанд 2-оос доошгүй жил ажилласан байх;	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- гүйцэтгэж буй ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг цуглуулах, харьцуулах, дүгнэх, санал боловсруулах, үр дүнг тайлагнах, илтгэх ур чадвартай байх;
	Асуудал шийдвэрлэх	- тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах; - хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдлийг шуурхай гаргах, - хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх,
	Багаар ажиллах	- мэдлэг, туршлага, ур чадвараа бусадтай хуваалцах, хамтран ажиллах, - хамт олны зэрэг, нээлттэй уур амьсгалыг бүрдүүлэх;

		<ul style="list-style-type: none"> - ёс зүйн хэм хэмжээг сахиж, ажил хэрэгч чанараараа бусдад үлгэрлэх, - ажлын цаг ашиглалт, хувийн зохион байгуулалт сайтай, - бусдад хүндэтгэлтэй, соёлтой, адил тэгш хандах,
	Бусад	<ul style="list-style-type: none"> - албан хэрэг хөтлөх, бодлогын баримт бичиг боловсруулах, - албан ажлын чиг үүргийн дагуу зөвлөгөө, мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх, - бүтээлч, санаачлагатай ажиллах, - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах, - кирилл болон үндэсний бичгээр баримт бичиг боловсруулах чадвартай байх, - гадаад хэлний мэдлэгтэй байх;

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
- Захиргаа, удирдлагын газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект:

- Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, харьяа байгууллагууд
- Бусад холбогдох төрийн байгууллага,
- Иргэн, хуулийн этгээд.

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Албан тушаал: ЗАХИРГАА,
УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Байгууллагын нэр: Соёлын өвийн үндэсний төв

Шийдвэрийн огноо: 2026.03.16

..... Г.АНХСАНАА
(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр,
өөрийн нэр)


Дугаар: А/13
(тамга/тэмдэг)
ЗАХИРАЛ Г.ЭНХБАТ

2026 оны ... дугаар сарын ... -ны өдөр

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр,
өөрийн нэр)

2026 оны 03 дугаар сарын 16 -ны өдөр

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн
А/13 дугаар тушаалын хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
 Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2026 оны А/2 дугаар тушаал

Дагаж мөрдөх огноо: 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Соёлын өвийн үндэсний төв

Албан тушаалын нэр:

Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

Ажлын цаг:

08.30-17.30

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Захиргаа, удирдлагын газар

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТҮ-7

Ажлын байрны албан ёсны байршил:

Хан-Уул дүүрэг, 21 дүгээр хороо, Буянт-Ухаа 2 хороолол

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх, сурталчлах, харилцах, байгууллагын олон нийтийн болон цаг үеийн шинжтэй арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх, сурталчлах, харилцах;
- Байгууллагын олон нийтийн болон цаг үеийн шинжтэй бусад арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;
- Байгууллагын болон нэгжийн дотоод үйл ажиллагаанд оролцох, тайлагнах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр: Туслах -Т, Хариуцан гүйцэтгэх -Г Хянах -Х Шийдвэрлэх -Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Байгууллагын үйл ажиллагааг байгууллагын цахим хуудас pcch.gov.mn , Соёлын өвийн үндэсний төв сошиал хуудас болон бусад цахим мэдээллийн сувгаар мэдээлэх, сурталчлах, газар нэгжүүдийн мэдээллийг нийтлэх;	Байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг цахим болон хэвлэл мэдээллийн сувгаар нийтэлж, олон нийтэд хүргэсэн байна.	Г
